



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/01

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн тогтоох тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын албан хэрэгцээнд зориулж техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Батсайхан (Татварын улсын байцаагч)

Гишүүд: Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

Ж.Энхзаяа (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн)

Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналт, шалгалт, олон нийт хариуцсан мэргэжилтэн)

2. Техникийн тодорхойлолт боловсруулан 3-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжээс үнийн санал авч нийлүүлэгчийг сонгон шалгаруулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Батсайхан)-д даалгасугай.



ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ